

СИНЬЗЯНЫ УУГУУЛ АРД ТҮМНИЙ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

М.ХУРМЕТХАН*

Тус нутгийн экологийн байдал нь аж ахуйн хэд хэдэн хэвшил-нүүдлийн, суурьшмал, хотын гэсэн төрлүүдийг бий болгожээ. Цаг уур нь хуурай байгаа нь түүх, соёлын олон сайхан дурсгалыг хадгалан, бидний үед хүргэж ирэх бололцоо олгосон байна.

СУӨЗО дахь ард түмнүүд түүхийнхээ туршид туурвин бүтээж нутгийнхаа хөрсөн доор болон дээр хадгалсаар ирсэн түүх, соёлын дурсгал нь өнөөгийн даяарчлалын үед дэлхийн хүн ардын үзэж сонирхох түүх, соёлын чухал дурсгалт зүйлийн нэг хэсэг болж байна.

Эртний түрэг хэлтэн ард түмний нэг-уйгурын ард түмний соёлын өв чухал байр эзлэх бөгөөд профессор Юсуп Зия Ширваны тэмдэглэснээр “эртний уйгурын соёл нь гүн гүнзгий агуулгатай, баялаг дурсгал үлдээсэн хийгээд дэлхийн соёлын санд өөрийн хувь нэмрээ оруулсан юм”¹ гэжээ.

Синьзяны эртний дундад зууны ард түмний түүх, соёлын бие даан хөгжүүлж, түүх, соёлын гайхамшигт дурсгалуудыг бий болгожээ. Эдгээр түүхийн дурсгалыг бий болгоход өрнө-дорнын соёлын нөлөөний үүргийг үнэлэн үзэх ёстой боловч, Дорнод Туркестаны уугуул оршин суугчид өөрсдийнхээ оюун ухаан, авьяас билэг, хүч хөдөлмөр, туршлагынхаа ачаар “бие даасан, дэвшилт шинж чанартай, түүхэн үйл явцыг өнгөрүүлж өвөрмөц соёлын өвийг хүн төрөлхтөний бүхий л түүхийн туршид хөгжүүлж ирснийг мартаж болохгүй юм”² гэж академич А.А.Окладников цохон заажээ.

Синьзяны түүх, соёлын гарал үүсэл хийгээд түүх нь Казахстан, Дундад Ази, Монголын нөлөөн дор хөгжиж ирсэн нь ажиглагдана. Эрт болон дундад зуунд ч

Дундад-Ази-Дорнод Туркестаны бүс нутагт угсаатан-соёлын нэгдмэл нэгдэл бүрэлдэн тогтож байжээ. Академич В.В.Бартольд “Туркестаны хоёр хэсэгт нь нэг гаралтай ард түмнүүд аж төрдөг бөгөөд мөн соёлын нэг л хүчин зүйл үйлчилж байдаг”³ гэж онцлон тэмдэглэжээ. Мөн түүнчлэн тус нутгийн түүх, соёлд бусад чиглэлээс, тухайлбал, Энэтхэг, Афганистан, Иран, Хятадын соёлын нөлөө байсныг үгүйсгэх аргагүй юм.

Эрт болон дундад зууны үед хятадын талаас соёлын нөлөө байсан хэдий ч төдийлөн өргөн биш байсан бөгөөд Кашгарын орон нутгийн эд өлгийн зүйлд болон оюуны соёлын амьдралд ул мөрөө үлдээжээ. Энэ нь хувцас хунар, буу зэвсэг, толь, нэхмэл эдлэл, цаас, уран барилга зэрэгт худалдаагаар дамжин ирж, нутгийн соёлд нэвтэрсэн зүйл байх ажээ.

Тус СУӨЗО-д 1956 онд материаллаг соёлын дурсгалыг судлах, хамгаалах үүрэгтэй байгууллагуудын сүлжээ бий болжээ. 1957 онд улсын хамгаалалтанд байвал зохих дурсгалт зүйлийн нэрсийн жагсаалтад 118 зүйл орсноос⁴ нь бүх Хятадын хэмжээний хамгаалалтад авах зүйл байв. Үүнд: Кызыл /Байчэн/, Кумутула /Куча/-гийн Мянган бурханы агуй, Турфаны хонхор дахь Гаочан, Ярху хэмээх эртний хотын туурь оржээ. 1961 онд хамгаалалтанд байсан 180 нэрийн зүйлээс хувьсгалт тэмцэлтэй холбоотой газар 32, агуй хийд, сүм 14, уран барилгын дурсгал 77, баримал хөшөө 11, хот балгасын хана 26, олон хэлбэрийн оршуулгын газар 19-ийг бүртгэжээ.⁵

Одоо СУӨЗО-д түүхийн дурсгалт зүйлийг хадгалан хамгаалах, судлах жуулчлалын байгууллага олон бий. Синьзяны археологчид судалгаа хийж, түүх, соёлын олон мянган

* М.Хурметхан. ШУА-ийн ОУСХ-ийн тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D) профессор

дурсгалт зүйлийг илрүүлэн, Синьзяны эртний түүх болон үндэстний соёлыг судлах, танилцуулах хангалттай баялаг материал бий болгожээ.

Өнгөрсөн зууны сүүлийн хориод жилд СУӨЗО-д архелогийн судалгаа идэвхтэй явагдан судалгааны хүрээ өргөжиж, түвшин дээшилж, шинжлэх ухааны шинэ шинэ олдвороор өргөжүүлэн баяжуулав. 1957-1977 оны хооронд архелогийн 400 олдвор олж, 1949 оноос 500 булш малтаж, 10 мянган олдвор олдож байсан бол, сүүлийн хориод жилд энэ хэмжээ хэд дахин их болов. Энэ бүхэн СУӨЗО-ны түүх, соёлын дурсгалт зүйлийг судлаачид болон жуулчдын анхаарлыг өөртөө гойд татаж байгаа юм. Эдгээр зүйлийн тухай “Синьзяны тухай ерөнхий ойлголт”, Б., 1985, “Синьзяны эртний ард түмнүүдийн материаллаг соёл”, Б., 1985, “Синьзяны материаллаг соёлын дурсгалууд” Б., 1975, ном болон “Вэньбу”, “Синьзяны шэхуй кэсюе” сэтгүүлийн хуудаснаас гүнзгий танилцаж болох юм.

СУӨЗО-ны эртний түүх, соёлын хамгийн нэртэй дурсгалуудыг танилцуулъя. Үүнд:

Эртний бууц. Их Торгоны замын дагуу байрласан Дорнод Туркестан нь Хуучин Ертөнцийн тольт зүрхний нэгэн судас байв. Тэгээд ч тус нутагт эрт, дундад зууны маш олон дурсгалт зүйлүүд хадгалагджээ. БНХАУ-ын холбогдох байгууллагуудын судалснаар Синьзян-Уйгурын Өөртөө Засах Оронд жуулчдын нүд хужирлах түүх, соёлын дурсгалт газрууд 479 байгаа хийгээд, жуулчлалын нөөцөөр тус СУӨЗО нь бүх Хятадын хэмжээнд 1-рт орж, гадаадын жуулчдыг хүлээн авах талаар хамгийн ирээдүйтэйд тооцогдож байна. Эдгээр дурсгалт зүйлүүд бол Дорнод Туркестаны уугуул оршин суугчдын оюун ухаан, биеийн хүчээр бүрдэн цогцолж, ихэнх хэсэг нь устсан хэдий боловч мөн зохих зүйл уламжлагдаж иржээ. Энэ бүхэн бол Дорнод Туркестан Төв Азийн соёлын нэгэн чухал голомт, түүхийн содон үзэгдэл байсныг нотолж байгаа юм.

Гаочан /Кочо/ хотын туурь нь Турфан хотоос зүүн-өмнөд зүгт 45 км газарт Карахожа хошууны нутагт оршино. М.Э.Ө I зуунд Гаочан хот Их Торгоны замын нэгэн чухал хэсэг байжээ. Хотын тэнхлэг багана одоо хүртэл хадгалагдан ирсэн бөгөөд хотын

тууриас барилгын үлдэц, цонх, хаалга, хөндий цүнхэг тааралдана. Хотын хойд талд Даосын сүм байх бөгөөд ханын зургууд хадгалагджээ. 1400 жилийн түүхийг туулсан уг хот XIV зуунд бууралтанд орж, зөвхөн туурь нь үлджээ.

Зяохэ /Хочо/ балгас Турфан хотын баруун талд 13 км газарт оршдог. Түүний нэр нь голын нэрээс гаралтай юм. Энд Дорнод Туркестанд оршин тогтнож байсан 36 хант улсын нэгнийх нь төв байжээ. Хотын туурийн талбай нь 1600м урт, 300м өргөн юм. Хотод сүм, дацан, орон сууцны үлдэгдэл хадгалагджээ. Хотын бүх туурь 470 мянган м² бөгөөд 360 мянган м² нь хадгалагджээ. Энэ хот дундад зууны хот байгуулалтын дүр төрхийг харуулах дурсгал билээ.

Безылыкскийн мянган бурхны агуй бол Турфан хотоос зүүн зүй 45 км байх бөгөөд өөрийн гайхамшгаар хосгүй, асар баялаг зургаар чимэглэсэн агуй –сүмийн цогцолбор юм. Уг цогцолборт 83 агуй, 40 илүү ханын зураг хадгалагджээ. Тэдгээр зурагт 7-8-р зууны лам хуврагуудын ахуй амьдралыг дүрсэлжээ. Агуй сүмийн барилга байгуулалтын сүүлчийнхийг 5-6-р зуунд барьжээ.

Астаны бунхан булш Турфанаас зүүн зүгт 40 км, Кочагийн балгасаас 3 кмт оршино. Эндээс 3-р зууны хоёрдугаар хагасаас 9-р зуунд холбогдох, 900 гектар талбай эзэлсэн, 500 булш илрүүлэн олж, судлах зорилгоор 3 булшийг хөнджээ. Булш бунхан сайн хадгалагдсан ба газар доорхи музей хэмээн нэрлэж байна.

Имины Минарет цамхаг бол Турфанаас зүүн тийшээ 2 кмт байрлажээ. Уйгурын уран барилга, исламын соёлын хосгүй дурсгал болсон уг байгууламж 1778 онд баригдсан хийгээд 37 м өндөр, дотор нь эргүүлсэн шаттай юм. Цамхаг уйгурын хээ угалзаар чимэглэгдсэн хийгээд энд үүнээс өөр цамхаг байхгүй юм. Цамхагийн дэргэд мечеть бий бөгөөд, уг цамхаг-мечетийг дөнгөж 1988 оноос төрийн хамгаалтанд авчээ. Өөрөөр хэлбэл, Турфан нь Яр-хото, Астан, Безылык, Кочо, Туйок зэрэг дурсгалуудаар алдартай.

Дорнод Туркестаны уугуул ард түмний бүтээсэн өөр нэгэн гайхамшиг бол эрт дээр үеэс бүтээсэн цоногт худаг юм. Энэ нь асар урт үргэлжлэх газар доорхи усан суваг бөгөөд

түүгээр мөс, булаг шанд, голын ус ууршилгүй урсаж, газар тариаланг усалдаг юм. Худаг бүр 20 м зайтай байж, худгийн усны хэмжээ дээшилж, газрын гадаргууд гарч, жижигхэн булаг үүсгэнэ. СУӨЗО-ны тариалангийн талбайн 75% нь ийм цоногт худгийн аргаар усжуулдаг бөгөөд тэдний тоо 1100, газар доорхи усан сувгийн урт нь 5 мянган км бөгөөд ач холбогдлоороо Хятадын цагаан хэрэм, Их Суваг /Бээжин-Ханьчжоу/-тай эн зэрэгцэнэ.

Мөн түүнчлэн Хотаны орчим Йоткан, Хотан, Равак, Дайдан-Уйлык, Ния, Эндере, Балавасте зэрэг дурсгалт газрууд байна. Йоткан бол Хотанаас зүүн баруун талд 10 км т оршино. Хотын туурийн хэмжээ 10 км². Хотын туурийг малтах явцад их хэмжээний түүхийн дурсгалт зүйл олджээ. Хотан тойрогт Ния хотын балгас байх бөгөөд энд 2 мянган жилийн өмнө нэгэн ханлигийн нийслэл оршин байжээ. Уг хотын туурийг археологчид эртний Помпейтэй зүйрлэн хэлэлцэнэ. Такламаканд байгаа өөр нэгэн эртний хотын туурь нь уртаар 25 км өргөнөөр 7 км байна.

Кашгар хот Этигарт мечетээр алдаршжээ. Уг мечеть Дорнод Туркестанд 500 жилийн өмнө баригджээ. Тэр нь исламын соёлын ач холбогдлоороо Бухар, Самаркандын мечетүүдтэй энэ зэрэгцэх юм. Мечеть 1442-1872 онд баригдсан бөгөөд исламын мечетийн бүх шинж төрхийг өөртөө агуулжээ. Кашгарын дорнод хэсэгт Аппак Ходжагийн бунхан байна. Түүний бунханы хажууд тэр үеийн Дорнод Туркестаны алдарт хүмүүсийг нутаглуулжээ.

Синьзянд түүхийн дурсгалт зүйл ихээр бөөгнөрсөн нутаг бол Аксугийн хавь нутаг болно. Энд Аксу, Кызыл, Долдур, Охур, Субаши, Куч, Кумтура зэрэг алдартай дурсгалт газрууд байна. Кучад бүгд иж бүрэн 4 бунханы сүмийн цогцолбор байх бөгөөд 472 агуй бүрэн хадгалагджээ. Кумтурагийн цогцолборын нэг хэсэг нь Куча хотоос баруун өмнөд талд 30 кмт байх бөгөөд уулын даваанд 117 агуй байрлажээ. Мянган Бурханы Кызылийн агуйгаас Миньюаньшань дахь агуйнууд алдартай юм. Мянган бурханы агуйн цогцолборт 236 агуй байх ба тэдгээрээс 136 нь бүрэн хадгалагджээ. Ханын зургийн хэмжээ 5 мянган м² бөгөөд ханын зурагт

Шакья-Муни амьдралын 67 зурвас үе дүрслэгдсэн байна.

Түүнчлэн Шорчук, Карашар, Хами, Лоулань, Миран, Юйминьд түүхэн дурсгалт зүй бий. Эдгээрээс Лобнуурын баруун эрэгт байгаа Лоулань хотын туурь сонирхол татдаг. Өнөөгийн байдлаар сөнөсөн хотын туурь 100 мянган м² газрын эзэлж байгаа бөгөөд байшингийн суурь, сүм хийд, орон сууц, харуулын цамхаг, оршуулгын газрын байрлал тод харагдана. Мөн энд Миран хотын туурь байх бөгөөд цайзын ханын өргөн 6-9 метр байжээ.

Тоглук Төмөр хааны бунхан Кульджагаас 80 кмт байна. Тэр бол Чингис хааны 7 дахь үеийн удам бөгөөд Дорнод Туркестанд исламын шашинд орсон анхны монгол хаан юм. Бунхан бол мусульманы архитектурын загвараар баригджээ. Дорнод Туркестанд өөр нэгэн гайхам сайхан дурсгалт зүйл бол Алтай уулын өвөр талаар Көктогайгаас Жеменай, Каба хүртэл мянган км үргэлжлэх хадны зураг юм. Зурагт голдуу ан амьтныг дүрслэн үзүүлсэн бөгөөд мянган жилийн өмнө зурагдсан уран зургийн үзэсгэлэн болно. Эдгээр зургууд Алтайн уулын уугуул иргэдийн үлдээсэн түүх, соёлын дурсгал юм. Эдгээр зургийг тус нутгийн нүүдэлчин ард түмнүүд өөрийн өв соёлын хувьд тасралтгүй баяжуулсаар ирсэн байна. Мянган жил улиран өнгөрсөн ч ихэнхи зургууд сайн хадгалагдан иржээ. Мөн Кашгарын базар, Шитоугийн бэхлэлт, Суритан бунхан, мечеть, сүм, хийд зэрэг бусад олон зүйлийг СУӨЗО-оос үзэж болох юм. Мэдээж, жуулчин хүн эдгээр түүхийн хосгүй дурсгалуудтай танилцахын хамт өнөөгийн СУӨЗО-ны хөгжил, цэцэглэл, ард түмэн, аж амьдралын бүх зүйлийг үзэж, харж, сонирхох нь зүй. Мөн түүнчлэн СУӨЗО-ны Тэнгэр уул, Алтай уул, Канас, Лоб, Айдын, Багрьш, Сайрам зэрэг нуур болон Алтын таг, Баянбүрдийн /Баянгол /дархан цаазат газар, Такламаканы энгүй элсэн цөл, галт уул зэрэг байгалийн хосгүй сайхныг үзэж сонирхох боломжтой. Мөн СУӨЗО-ны уйгур, казах, монгол, хан зэрэг угсаатан-үндэстний аж төрөл, зан заншил, баяр наадам, уран зохиол, хувцас, телевиз, сонин хэвлэл, хоол унд, шашин шүтлэгийн байдал бас таны хараанд өртөх биз.

Мөн Синьзяны түүхийн музейгээс эртний оршин суугчдын үлдээсэн ахуйн хэрэглээний олон зүйлтэй танилцах боломж бий. Энд цаас, мод, төмөр, арьс, торго, хөвөн даавуунд бичсэн ном байна. Алтай, Тарбагатай, зэрэг газраас олдсон 3 мянган жилийн өмнөх ваарын эдлэл, хувин, данх зэрэг болон 2500-3000 жилийн өмнөх хүрлийн дурсгал-хутаг, сүх, толь, эмээлийн тоноглол болон 2400 жилийн настай хүрэл таваг нь 2400 жилийн настай, дөрвөлжин хэлбэртэй, хос арслангийн дүрсээр чимэглэлсэн хийгээд Синьзяны Төв музейд хадгалагдаж байна.⁵ Мөн эртний мөнгө, ном хэвлэл, Дорнод Туркестанд ихээр олдож байгааг та нүдээр харах болно. Эдгээр дурсгалыг Казах, Орос, Их Британи, Франц, Герман, Швед, Финлянд, Япон болон Хятадын эрдэмтэд тал бүрээс нь судалж ирсэн билээ.⁶

Ашигласан материал:

1. Рузиев М. Возрожденный уйгурский народ. А., 1978. с. 7-8
2. Окладников А. П. Изучение истории в Сибири. Отделении АН СССР. Новосибирск.. 1975. №6., с. 39-40
3. Бартольд В. В. Сочинения. т. 9., М., 1977. с. 521
4. Восточный Туркестан и Средняя Азия в системе культур древнего и средневекового Востока. М., 1986. с. 31
5. Синьцзян Китая. Изд. "Учжоу Чуаньбо" . 1999.
6. Восточный Туркестан в древности и раннем Средневековье. М., 1988, Восточный Туркестан в древности и раннем средневековье. М., 1992